



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**
Гүйцэтгэлийн аудитын алба



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т
хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ГАГ-2020/02/-ГА

Чойбалсан хот 2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
Аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1.УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	7
A.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байгаа ч төлөвлөлтийн үе шатны арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байна.....	8
A.1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2019 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцэж байна.....	9
A.1.2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.....	10
A.1.3 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх ажил хангалттай, үр дүнтэй хийгдэхгүй байна.....	11
A.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх байдал хангалтгүй байна.....	12
A.2.1 Барилга, байгууламжийн зураг, төсвийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.	12
A.2.2 Барилга, байгууламжийн төсөвт өртгийг зохиох норм, дүрэм өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.....	13
A.2.3 ТАХ-ний зураг, төсөвт магадлал хийх ажил хуульд заасан хугацаанд хийгдэхгүй байгаагаас төсөвт өртөг өөрчлөгдөж байна.....	13
A.2.4 Шинээр хийгдэх барилга байгууламжийн зураг төсвийг хууль батлуулснаас хойш боловсруулж, баталгаажуулдаг зөрчил арилаагүй байна.....	14
A.2.5 Байршил тодорхойгүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй төсөл, арга хэмжээг хуульд тусган баталсан байна.	14
A.2.6 Төсөл арга, хэмжээний санхүүжилтийг жишиг зургийн төсвөөр баталснаас шалтгаалж, хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүссэн байна.	14
A.2.7 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.....	15
БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТӨЛӨВЛӨЛТИЙН ХАНГАЛТГҮЙ БАЙДАЛ НӨЛӨӨЛЖ БАЙНА.	15
B.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.	15
B.1.1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний 94.0 хувийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.	16
B.1.2. Тендерийг зарлахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажиллаагүй байна.....	16
B.1.3. Зураг хийгдээгүй, ажлын даалгавар дутуу ажлуудад ХАА-г зохион байгуулсан байна.....	16
B.1.4. Тендер шалгаруулалтад оролцогсдын өрсөлдөх боломжийг бодитой үнэлэхэд анхаарах асуудал байна.....	16
B.1.5. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.....	17
B.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй байна.....	17
B.2.1. Гэрээний хугацаанаас хэтэрсэн, чанаргүй хийгдсэн ажлууд байна.....	17
B.2.2. Хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй байхад ажлыг хүлээн авсан байна.....	17
B.2.3. Гүйцэтгэгчид нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	18
B.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	18



Б.3.1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	18
Б.3.2. Он дамжин гүйцэтгэгдэж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.....	19
Б.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2019 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.....	19
Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд хүрэх зорилтот түвшинд бүрэн хүрээгүй, үр ашгийн талаарх тооцоо судалгаа хангалтгүй байна.	19
Б.4.1. Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоогүй, зорилтот үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээ байна.....	20
Б.4.2. Санхүүжилтийг олгохдоо СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.....	21
Б.4.3. Шинээр ашиглалтад орсон барилгуудыг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.....	22
Холбогдох байгууллагын санал:	23
Саналд өгсөн тайлбар:	24
ДҮГНЭЛТ:	24
ЗӨВЛӨМЖ:	25
ТУШААЛ:	26



Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол Улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг Дарга
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГХБХБ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт



Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	"Төсөв батлагдсанаас хойш хийгдсэн зураг, төсөв"	10
Хүснэгт 2	"Тендер зарласан хугацаа"	12
Хүснэгт 3	"2019 онд улс, орон нутгийн төсвөөс 3-аас дээш тендер авсан ААН-үүд"	14
Хүснэгт 4	"Гэрээнээс хэтэрсэн хоног, шалтгаан"	15
Хүснэгт 5	"Захиалагч, зохиогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт"	17



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газарт хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх, ➤ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвөөс 2019 онд эрх шилжиж ирсэн 18 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгадагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн ИТХ болон Засаг даргад 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлээ.



А.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байгаа ч төлөвлөлтийн үе шатны арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байна.

А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2019 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцэж байна.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт 40 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 18 төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн байна.

Эдгээр төсөл, арга хэмжээний 77.7 хувь нь нийгмийн салбарт буюу боловсрол, эрүүл мэндийн салбарт чиглэхээр төлөвлөгдсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцсэн байх шаардлагатай.

МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий төсөл, арга хэмжээ хамаардаг учраас Дорнод аймагт 2019 онд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд уг хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эдгээр 18 төсөл, арга хэмжээ нь нийцсэн байна.

А.1.2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь захиалагчдын саналд үндэслэсэн байх шаардлагатай.

Орон нутагт эрх шилжиж ирсэн 18 төсөл, арга хэмжээнээс 14 төсөл, арга хэмжээний саналыг холбогдох төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу аймгийн ТЕЗ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн байна.

Харин 4 төсөл, арга хэмжээний санал нь ашиглагч байгууллагаас УИХ-ын гишүүнд хүргүүлсэн саналаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна. Үүнд:

- Улз голын урсцыг нэмэгдүүлэх “Онон-Улз” төсөл /Онон-Улз голын сав газрын захиргаанаас санал хүргүүлсэн/.
- Зүүн бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн барилгын шугам сүлжээ /Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас санал хүргүүлсэн./



- Матад сумын цэцэрлэгийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, тохижилт их засварын ажил /Матад сумын ЗДТГ-аас санал хүргүүлсэн./
- Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод их сургуулиас санал хүргүүлсэн./

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөгдсөн хүчин чадал нь захиалагчийн санал, орон нутгийн суурь үзүүлэлтүүдэд нийцсэн байна.

А.1.3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх ажил хангалттай, үр дүнтэй хийгдэхгүй байна.

Улсын төсвөөр 2019 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам” мөрдөгдөж байсан. Төсвийн тухай хууль болон уг журамд зааснаар аймгийн ТЭЗ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцон эрэмбэлсэн байх шаардлагатай.

Аймгийн ЗДТГ-ын улсын төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрэмбэ нь дээрх шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд ХОХБТХ-ээс эрэмбийн талаар ирүүлсэн цахим файлд, төсөл арга хэмжээнүүдийн төсөв байхгүй, шинээр бий болох ажлын байрны талаарх судалгаа буруу, эрэмбийн дугаар давхардсан байна. Мөн хэрэгцээ, үр ашиг, ач холбогдлыг тооцсон тооцоо судалгаа, хэлэлцэн үнэлсэн хурлын тэмдэглэл, баталгаажуулсан баримт материал байхгүй байна.

Өмнөх онуудад эрэмбэлэх ажил хангалтгүй хийгдэж байгаа талаар тайланд тусган, зөвлөмж хүргүүлж байсан ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг зөв үнэлээгүй, үр ашгийг тооцоогүй төсөл арга хэмжээ төсөвт тусгагдан батлагдах нөхцөл байдлыг үүсгэж байна. Тухайлбал: Баян-Уул сумын Соёлын төвийн барилга нь 2004 онд ашиглалтад орсон боловч зориулалтын бус гэсэн шалтгаанаар 2019 онд шинэ барилга бариулахаар улсын төсөвт тусгуулсан байна. Мөн Дашбалбар, Чойбалсан, Баяндун сумын сургуулийн их засварын ажлуудын төсвийг тооцоог бодитой хийгээгүйгээс хэрэглэгчийн сэтгэл ханамж болон зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

Иймд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ыг мөрдөж ажиллах нь зүйтэй байна.

А.2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх байдал хангалтгүй байна.

А.2.1. Барилга, байгууламжийн зураг, төсвийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.

Барилга, байгууламжийн зураг, төсвийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлээгүй дараах ажлууд байна.

- Баянтүмэн сумын цэцэрлэгийн барилгын төсөвт уурын зуухны ажлын 560.0 сая төгрөгийн ажлын төсөв тусгагдаагүй байна.
- Баян-Уул сумын соёлын төвийн барилгын төсөвт цахилгааны сүлжээ болон дотор, гадна сантехникийн шугамын ажлын 362.0 сая төгрөгийн төсөв тусгагдаагүй байна.



- Баяндун сумын сургуулийн дотуур байрны барилгын зурагт захиалагч, хэрэглэгчээс тавьсан зоорийн давхрын өрөөг нэмэгдүүлэх саналыг тусгах боломжгүй гэсэн хариуг өгсөн байна. Учир нь барилгын зураг 2011 онд хийгдсэн тул зоорийн өрөөг нэмэгдүүлэхэд суурийн үндсэн хийцэд өөрчлөлт орохоор байна.
- Цагаан-Овоо сумын соёлын төвийн барилгын их засварын зургийг хийхдээ хэрэглэгчээс санал аваагүй тул уг барилгыг засуулах гол шаардлагыг үүсгэсэн шал солих, барилгын хаяавч хийх ажлууд тусгагдаагүй байна.
- Хэрлэн сумын 6 дугаар багт баригдсан цэцэрлэгийн барилгын гадна талбай, унтлагын өрөө нь СӨБ-ын сургалтын орчны стандартад нийцээгүй, зарим өрөө агааржуулагчгүй, биеийн тамирын өрөө зураг төсөвт нь тусгагдаагүй, цахилгааны дэд станц ТЭЗҮ, зураг төсөвт тусгагдсан ч төсвийг хасаж баталсан байна.
- Хэрлэн сумын 1 дүгээр багт баригдсан цэцэрлэгийн барилгын зураг, төсөв унтлагын өрөөгүй батлагдсан нь СӨБ-ын сургалтын орчны стандартад нийцэхгүй байна.

Энэ нь тухайн ажлууд хуульд заасан хугацаандаа дуусахгүй, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байгаа бөгөөд захиалагч зураг, төсвийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, төсвийг бүрэн батлуулах шаардлагатай байна.

А.2.2. Барилга, байгууламжийн төсөвт өртгийг зохиох норм, дүрэм өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.

Барилга байгууламжийн төсөвт өртгийг зохиохдоо **Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны тушаалаар батлагдсан норм, дүрмийг баримтлан ажилласан байна.**

Төсөвт өртөг тооцох программд шинэчлэл хийгддэг ч норм, дүрэмд үе шатны ажлуудын ажиллах хүчний зардал бодит байдлаас хэт хэлбэлзэлтэй, машин механизм, техник хэрэгслийг зөөн байршуулах зардал тусгагддаггүй асуудлууд байсан байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалаар Барилгын төсөв зохиох, норм, дүрэм шинэчлэн батлагдсан ч 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөхөөр заасан байна.

А.2.3. ТАХ-ний зураг, төсөвт магадлал хийх ажил хуульд заасан хугацаанд хийгдэхгүй байгаагаас төсөвт өртөг өөрчлөгдөж байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 18 төсөл, арга хэмжээний зураг төсвөөс 13 нь ЗГ-ын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан **“Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, магадлал хийх дүрэм”-ээр** магадлал хийлгэх шаардлагагүй их засвар хийх, тоног төхөөрөмж авах, зураг төсөв боловсруулах ажлууд байна.

Барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах, магадлал хийх дүрэмд, аймгийн ерөнхий архитектороор батлуулж, ТЕЗ болон холбогдох албан тушаалтнуудаар зөвшөөрүүлсэн ажлын зураг төсөвт магадлал хийхээр заасан байна.

Магадлал хийлгэх шаардлагатай 5 төсөл арга хэмжээний зураг төсөвт Барилгын тухай хуулийн 25 дугаар заалтын дагуу магадлал хийлгэж баталгаажуулсан ч Баяндун сумын сургуулийн дотуур байрны барилгын ажлаас бусад 4 ажлын зураг төсөвт 2019 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш



магадлал хийгдсэн байна. Магадлалаар 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өөрчлөгдсөн байна. Үүнд:

- Цэцэрлэгийн шинэ барилга /Баянтүмэн сум/- Төсөв батлагдсанаас хойш магадлал хийгдэж төсөвт өртөг нь 560.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Соёлын төвийн барилга /Баян-Уул сум/- Төсөв батлагдсанаас хойш магадлал хийгдэж төсөвт өртөг нь 362.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Магадлал хийгдээгүй ажлууд батлагдаж байгаа нь төсөл, арга хэмжээний төсөвт өртөг төлөвлөгдсөн дүнгээс өсөх, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн болон төсвийн зарцуулалтын үр ашгийг бууруулах үр дагавартай байна.

Энэ нь зураг, төсвийн зохиогчтой гэрээ байгуулсан тохиолдолд гэрээнд тусгагдсан санхүүжилтийг олгох асуудал үүсдэгээс төсөвт тусгагдан батлагдсан ажлуудын зураг төсөвт л магадлал хийлгэж байгаатай холбоотой байна.

Иймд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн зураг төсөвт хуульд заасан хугацаанд магадлал хийлгэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

А.2.4 Шинээр хийгдэх барилга байгууламжийн зураг төсвийг хууль батлуулснаас хойш боловсруулж, баталгаажуулдаг зөрчил арилаагүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 18 төсөл, арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь улсын төсөв батлагдсанаас хойш хийгдэж, баталгаажсан байна. Үүнд:

Хүснэгт №1. "Төсөв батлагдсанаас хойш хийгдсэн зураг, төсөв" /сая төгрөгөөр/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Зураг төсөв хийгдсэн он
1	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга /Хэрлэн сум/	800.0	2019
2	Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Хэрлэн сум/	2,500.0	2019
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянтүмэн сум/	1,300.0	2019
4	Цэцэрлэгийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, тохижилт их засвар /Матад сум/	300.0	2019
5	Соёлын төвийн барилга /Баян-Уул сум/	1,255.0	2019
6	Соёлын төвийн барилгын их засвар /Цагаан-Овоо сум/	530.0	2019
	Дүн	6,685.0	

- Эдгээрээс Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга, Баянтүмэн сумын цэцэрлэгийн барилга, Баян-Уул сумын соёлын төвийн барилга гэсэн 3 төсөл, арга хэмжээ нь жишиг зургаар батлагдсан байна.
- Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төслийн ажил нь зураг, төсөвгүй батлагдаж 2019 онд 1.1 тэрбум төгрөгийн ажил хийгдэхээр байсан ч 221.0 сая төгрөгөөр зөвхөн ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн байна.
- Матад сумын цэцэрлэгийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, тохижилт их засварын ажлын анхны санал шинэ цэцэрлэгийн барилгад дэмжлэг авах байсан ч хууль батлагдах явцад засварын ажил болгон өөрчилж зураг, төсвийг шинээр хийлгэсэн байна.



- Цагаан-Овоо сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлыг 2016 онд хийсэн зураг, төсвөөр төсөвт батлуулсан 2019 онд шинэчилсэн байна.

Аудит хийх явцад сум, орон нутгийн удирдлагууд болон төсөв захирагчдын зүгээс “зураг төсөв хийлгэсэн ч төсөвт тусгагдан батлагдаагүй тохиолдолд төсөв хуучрах, дахин хийлгэх, өмнөх төсөв нь одоогийн үнэ ханшаас зөрүүтэй болох асуудал үүсдэгээс ажлыг жишиг зургаар батлуулах байдал үүсэж байгаа” талаар тайлбар өгч байсан.

Иймд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн зураг төсвийг хийлгэх ажлыг орон нутгийн түвшинд, эрэмбийн дүнг харгалзан нэгдсэн байдлаар шийдвэрлэж, орон нутгийн төсөвт тусгах нь зүйтэй байна.

А.2.5. Байршил тодорхойгүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй төсөл, арга хэмжээг хуульд тусган баталсан байна.

Орон нутагт эрх шилжсэн 18 төсөл арга хэмжээнээс Улз голын урсцыг нэмэгдүүлэх “Онон-Улз” төслийн ажлын барилга байгууламжийн газрын зөвшөөрөл нь 2019 оны төсвийн хууль батлагдахаас өмнө шийдвэрлэгдээгүй байна.

Энэ нь уг төсөл, арга хэмжээ зураг, төсөвгүй батлагдаж, 2019 онд ТЭЗҮ зураг төсвийг хийлгэснээр байршил тодорхой болж, Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргад газрын зөвшөөрөл авах тухай саналыг 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн нь шийдвэрлэгдээгүй байна.

А.2.6. Төсөл арга, хэмжээний санхүүжилтийг жишиг зургийн төсвөөр баталснаас шалтгаалж, хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүссэн байна.

Аудитын хамрах хүрээний 18 төсөл арга хэмжээнээс 3258.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний санхүүжилт хугацаандаа олгогдож, ажил нь хийгдсэн байна. Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг, төсөв, ТЭЗҮ хийх 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил хугацаандаа хэрэгжээгүй нь санхүүжилтээс шалтгаалаагүй байна.

Он дамжин хэрэгжихээр батлагдсан 7,685.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнээс 1300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баянтүмэн сумын цэцэрлэгийн шинэ барилга, 1255.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баян-Уул сумын соёлын төвийн шинэ барилгын санхүүжилт бүрэн батлагдаагүйгээс хугацаандаа хэрэгжих боломжгүй болох нөхцөл байдал үүссэн байна. Энэ нь төлөвлөлт жишиг зургаар хийгдсэнээс шалтгаалсан байна.

А.2.7. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр эрх шилжиж ирсэн нийт төсөл, арга хэмжээний 44.4 хувийг барилга байгууламж, 50.0 хувийг их засвар, 5.6 хувийг тоног төхөөрөмж худалдан авах ажилд зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Эдгээр төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;” гэж тодорхойлсон заалтад бүрэн нийцэх хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлууд байна.



Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд төлөвлөлтийн хангалтгүй байдал нөлөөлж байна.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Б.1.1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний 94.0 хувийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.

Дорнод аймгийн Засаг даргад 2019 онд 18 төсөл, арга хэмжээний эрхийг холбогдох салбарын сайдуудаас шилжүүлсэн байна. Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11-д заасны дагуу 2019 оны төсвийн тухай хууль батлагдсан 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс хойших хугацаагаар тооцон үзэхэд, эрхийг 2019 оны 01 сарын 02-ны өдөр хүртэл буюу 60 хоногийн дотор шилжүүлэхээр байсан байна.

Үүнээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах 1 төсөл, арга хэмжээний эрхийг 2018 оны 12 сарын 26-ны өдөр буюу хугацаанд нь эрх шилжүүлж, бусад 17 ажлыг 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 14-нийг хүртэл 8-42 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

Энэ байдал нь тендер төлөвлөгөөнөөс оройтож зохион байгуулагдах, худалдан авах ажиллагаа амжилтгүй болж хугацаа сунгагдсан тохиолдолд төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нөлөөлж байна.

Б.1.2. Тендерийг зарлахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажиллаагүй байна.

Тендерийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас оройтож зарласан дараах ажлууд байна.

Хүснэгт №2. “Тендер зарласан хугацаа”

№	Төсөл арга хэмжээний нэр	Тендер зарлах огноо	Тендер зарласан огноо	Хэтэрсэн хоног
1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн/	2019.02.11	2019.07.19	158
2	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/	2019.02.11	2019.05.17	95
3	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/	2019.02.11	2019.04.23	71
4	Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод, Хэрлэн сум/	2019.02.11	2019.06.14	123
5	Соёлын төвийн барилга, 250 ор /Дорнод, Баян-Уул сум/	2019.02.11	2019.08.02	172
6	Соёлын төвийн барилгын их засвар /Дорнод, Цагаан-Овоо сум/	2019.02.11	2019.05.02	80
7	Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/	2019.03.05	2019.10.16	225

Тендер оройтож зарласан шалтгаан нь эрхийг хугацаа хоцроон шилжүүлж, төлөвлөлтийн урьдчилсан тооцоо судалгаа дутуу, зураг төсөв оройтож хийгдэж байгаатай холбоотой байна.



Б.1.3. Зураг хийгдээгүй, ажлын даалгавар дутуу ажлуудад ХАА-г зохион байгуулсан байна.

Тендерийн үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан “Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг”-ийг баримтлан боловсруулсан боловч ажлын зураг, ажлын даалгавар бүрэн хийгдээгүй, зураг, төсөв зөрүүтэй ажлуудад худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тухайлбал:

- “Хэрлэн сумын 5-р цэцэрлэгийн барилгын их засвар”-ын ажлын төсөв хийгдсэн боловч, ажлын зураг байхгүйгээс тендер шалгарсны дараа мэргэжлийн байгууллагаас үүрэг даалгавар өгсний дагуу ажлыг түр зогсоож, зураг хийлгээний дараа гүйцэтгүүлсэн байна.
- “Баян-Уул сумын соёлын төвийн барилга”-ын ажлын зураг, төсөв зөрүүтэй буюу зурагт байсан зарим ажил төсөвт багтаагүй, хасагдаж батлагдсан байна.
- “Баянтүмэн сумын цэцэрлэгийн барилга”-ын ажилд 560.0 сая төгрөгийн дутуу төсвөөр худалдан авах ажиллагааг зарласан.
- “Цагаан-Овоо сумын соёлын төвийн барилгын их засвар”-ын ажлын зурагт хэрэглэгчээс саналыг аваагүй, зураг нь 2016 онд хийгдэж, тайзны шал, хаяавч нь батлагдсан зурагт тусгагдаагүй байна.
- “Чойбалсан сумын сургуулийн барилгын их засвар”, “Дашбалбар сумын сумын сургуулийн барилгын их засвар”-ын ажлуудад ажлын даалгаврын тоо хэмжээ дутуу, тухайн барилгын бодит байдлыг үнэлэлгүй худалдан авах ажиллагааг зарласан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19.2¹ дахь заалтыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Зураг, ажлын даалгавар боловсруулагдах хугацааг хүлээж тендер зарлах, тендер шалгарсны дараа зураг хийгдэх, төсвийг зургаас зөрүүтэй тусгах, захиалагч ажлын даалгаврыг боловсруулахдаа бодит нөхцөл байдлыг бүрэн үнэлээгүй зэрэг нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нөлөөлж, хугацаа удаашрах, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

Тендерийн баримт бичгийг боловсруулах үнэлгээний хороог байгуулахдаа аймгийн ИТХ, ЗДТГ, ОНӨГ, ТББ, мэргэжлийн байгууллагын төлөөллийг хамруулсан ч тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөллийг хамруулаагүй нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 47.4² дэх заалтад нийцэхгүй байна.

Мөн аудитын явцад барилгын ажлын тендерт оролцсон зарим компаниудаас үнэлгээний хороонд мэргэжлийн холбоодын төлөөлөл буюу мэргэжлийн төсөвчин оруулж байх талаар санал хүсэлтээ ирүүлсэн.

Иймд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хуульд заасан төлөөллийг бүрэн оролцуулж, тендерийн баримт бичгийг боловсруулалтыг сайжруулах шаардлагатай байна.

¹ 19.2.Тендерийн баримт бичигт тендер оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендер оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

² Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.



Б.1.4. Тендер шалгаруулалтад оролцогсдын өрсөлдөх боломжийг бодитой үнэлэхэд анхаарах асуудал байна.

Дорнод аймагт эрх нь шилжсэн 18 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй байдлаар цахим хэлбэрээр зарласан байна. Үүнээс 250.0 сая төгрөгийн өртөгтэй “Суурин рентген аппарат нийлүүлэх” ажлын тендер шалгаруулалттай холбоотой санал, гомдол 1 оролцогч гаргасныг Сангийн яаманд хүрүүлж, тендерийг дахин зарлах шийдвэр ирүүлснийг хэрэгжүүлсэн байна. Бусад тендер шалгаруулалттай холбоотой гомдол, санал гараагүй байна.

Аудитын явцад тендер шалгаруулалтын байдлыг үнэлэхэд, аж ахуйн нэгж, компанийн ажиллах хүч, нийт авсан тендерийн тоо, техник, тоног төхөөрөмж зэргийн бодит нөхцөл байдлыг харгалзан үзээгүйгээс тухайн төсөл, арга хэмжээ хугацаа хоцрох, чанаргүй хийгдэх эрсдэл үүссэн байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс 3-аас дээш тооны хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан компаниудын ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №3. “2019 онд улс, орон нутгийн төсвөөс 3-аас дээш тендер авсан ААН-үүд”

№	Аж ахуйн нэгжийн нэр	Улсын төсөв /ТАХ-ын тоо/	Гэрээний дүн	Орон нутгийн төсөв, ОНХС /ТАХ-ны тоо/	Гэрээний дүн	НИЙТ ТАХ тоо	НИЙТ төсөв /сая.төг/
1	“Бүжнар” ХХК	2	399.8	2	168.0	4	561.8
2	“Донж өргөө” ХХК	3	651.8	1	48.9	4	700.7
3	“Ган октаэдр” ХХК	2	159.6	3	652.5	5	812.1
4	“Талын сүлд” ХХК	2	1667.3	2	120.0	4	1787.3
5	“Дорнод хийц” ХХК	1	102.1	2	227.9	3	330.0
6	“Зэт Ай И Ти” ХХК	1	72.1	2	121.9	3	194.0
7	“Элтрүүд” ХХК	1	40.4	8	302.4	9	342.8

“Ган октаэдр” ХХК, “Талын сүлд” ХХК, “Элтрүүд” ХХК, “Зэт Ай И Ти” ХХК “Дорнод хийц”, “Донж өргөө” ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын чанарт асуудал гараагүй бөгөөд “Дорнод хийц” ХХК, “Донж өргөө” ХХК, “Зэт Ай И Ти” ХХК, “Элтрүүд” ХХК-иудын гүйцэтгэсэн 1 ажил тус бүр 2-21 хоног хугацаа хоцорсон, “Бүжнар” ХХК-ийн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 2 төсөл, арга хэмжээ нь чанаргүй хийгдсэн байдалтай байна.

“Бүжнар” ХХК-ийн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 2 төсөл, арга хэмжээ нь чанаргүй хийгдсэн нь ажиллах хүчин, техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй байсантай холбоотой байна.

Мөн үнэлгээний хороо нь ирүүлсэн тендерийн баримт бичгийг буруу үнэлсэн зөрчил илэрсэн. Тухайлбал: Баянтүмэн сумын цэцэрлэгийн барилгын ажилд ирүүлсэн тендерийн материалд “Талын сувд” ХХК, “Ган-Октаэдр” ХХК-уудыг татварын илүү төлөлттэй байхад өртэй гэж дүгнэсэн байна.

Иймд сонгон шалгаруулалтыг хийхдээ нөхцөл байдлыг бодитой, зөв үнэлэх нь зүйтэй байна.

Б.1.5. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.

Дорнод аймагт улсын төсвийн 2019 хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг хагас жил, жилийн эцсийн



байдлаар гаргаж, Сангийн яамны хууль, эрх зүйн газрын худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Нийт тендер шалгаруулалтын 17 нь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 1 нь зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох шалгаруулах журмаар зохион байгуулагдсан байна. Шалгарсан гүйцэтгэгчийн 77 хувь буюу 14 нь орон нутгийн гүйцэтгэгч байна.

Төлөвлөсөн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар аймгийн Засаг даргын захирамжаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, 18 хүнийг хамруулсан 5 үнэлгээний хороо байгуулж, үнэлгээний хороонд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч 4, аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн 5, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн 1, иргэдийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 4, Орон нутгийн өмчийн газрын 4 ажилтан тус тус орж ажилласан байна.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй байна.

Б.2.1. Гэрээний хугацаанаас хэтэрсэн, чанаргүй хийгдсэн ажлууд байна.

Дорнод аймагт улсын төсвөөс эрх нь шилжсэн ажлуудаас 2019 онд хэрэгжиж дуусах 12, онд дамжин гүйцэтгэгдэх 6 төсөл, арга хэмжээ байна. Бүрэн хэрэгжсэн ажлуудаас хугацаа хоцорч гүйцэтгэсэн 3 төсөл, арга хэмжээ байна

Хүснэгт №4. "Гэрээнээс хэтэрсэн хоног, шалтгаан"

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэтэрсэн хоног	Гүйцэтгэгч компани	Тайлбар, шалтгаан
1	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/	496.6	3	"ЦОДММ" ХХК	Цаг агаарын нөхцөл байдал, ажлын даалгаврыг бодитой боловсруулаагүй, тендер оройтож зарласан.
2	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/	300.0	2	"Бүжнар" ХХК	Цаг агаарын нөхцөл байдал, ажлын даалгаврыг бодитой боловсруулаагүй, давхар ажил авсан.
3	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дорнод, Хэрлэн сум, 1, 5, 8, 14 дүгээр цэцэрлэг/	25.0	4	"Донж өргөө" ХХК	Давхар ажил гүйцэтгэсэн.
		105.0	21	"Дорнод хийц" ХХК	Цаг агаарын нөхцөл, давхар ажил авсан.
		75.0	3	"Зэт Ай И Ти" ХХК	Давхар ажил гүйцэтгэсэн.
		45.0	3	"Элтрүүд" ХХК	Давхар ажил гүйцэтгэсэн.
		1046.6	36		

Эдгээр ажлуудад алдангийг бүрэн тооцож, нийт төлбөрт 1.9 сая төгрөгийг суутгасан байна.

Аудитын явцад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэхэд гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн дараах ажлууд байна. Үүнд:




1. “ЦОДММ” ХХК-ийн 496.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэсэн “Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/”-ын ажлын хувьд спорт заалны шал зай завсартай, овойж мөргөсөн, харуулдах, давхарлаж будах ажил дутуу, цонхны тавцан, хана, шалны будаг ховхорч, хууларсан, байдалтай байна. Барилгын дулаан алдалт өмнөх төвшнөөс буураагүй байна.



Дашбалбар сумын спорт заалны шал, анги, танхимын шугам, цонхны засвар

2. “Бүжнар” ХХК-ийн 110.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэсэн “Спорт заалны их засвар /Дорнод, Баяндун сум/”-ын ажлын хувьд спорт заалны шал стандарт бус материалаар хийхээр төсөвт тусгагдан хийгдсэн, шалыг тэгшилж харуулдах, давхарлаж будах ажил дутуу, хана таазны будаг ховхорч, хууларсан, цан цохиж харласан байдалтай байна.



Баяндун сумын сургуулийн спорт заалны засвар

3. “Бүжнар” ХХК-ийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэсэн “Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/”-ын ажлын хувьд коридорын хана хууларч, ховхорсон, спорт заалны шал стандарт бус материалаар хийхээр төсөвт тусгагдан хийгдсэн, зай завсартай, харуулдаж тэгшлээгүй, будгийн ажил дутуу хийгдсэн байдалтай байна.



Чойбалсан сумын сургуулийн дотор засал, спорт залны шалны засвар

Эдгээр ажил дахь ашиглагч байгууллагын сэтгэл ханамж 40-70 хувьтай байгаа бөгөөд ажлын чанарт төлөвлөлтийн алдаа болон гүйцэтгэгч компанийн хариуцлага аль аль нь нөлөөлсөн байна.

Б.2.2. Хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй байхад ажлыг хүлээн авсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.11-д заасны дагуу захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй дараах ажлууд байна.

Үүнд:

Хүснэгт №5. “Захиалагч, зохиогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт”

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэсэн компани	Өгсөн үүрэг даалгавар	Тайлбар
1	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/ 496.6 сая төгрөг	“ЦОДММ” ХХК	Норсон хананы засварыг 2020 оны хавар дахин засварлах.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн үлдсэн хэсгийг 2020 оны 06-р сард багтаан гүйцэтгэнэ.
2	Спорт заалны их засвар /Дорнод, Баяндун сум/ 110.1 сая төгрөг	“Бүжнар” ХХК	Ханын хуурсан хэсгийг засаж, дахин будах Шалыг харуулдах, давхарлаж будах	Үүрэг даалгаврыг 2020 оны 08 дугаар сард багтаан гүйцэтгэнэ.
3	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/ 300.0 сая төгрөг	“Бүжнар” ХХК	-Шалыг дахин шахах, норсон хэсгийг засварлаж, дахин будах	Үүрэг даалгаврыг 2020 оны 08 дугаар сард багтаан гүйцэтгэнэ.

Эдгээр ажлуудыг тайлант онд цаг хугацааны хувьд бүрэн дуусгах боломжгүй тул, санхүүжилт татуулахгүй байх зорилгоор, хугацаатай үүрэг, даалгавар өгч ажлыг хүлээн авдаг жишиг тогтсон байна.



Энэ нь хөрөнгө оруулалтын ажлын үр дүн буурах, хөрөнгө, нөөц үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай байна.

Иймд төсөл арга хэмжээний төлөвлөлтийг зохистой хийж, ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Б.2.3. Гүйцэтгэгчид нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Гүйцэтгэгч компаниуд төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тухайн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн баримтыг хөрөнгө оруулалтын ажлын төсөв, гүйцэтгэлтэй тулган шалгалаа.

Орон нутагт эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шалгарсан нийт 17 аж ахуйн нэгжээс орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуйн нэгж байна. Аудитын явцад орон нутгийн 7 аж ахуйн нэгжийг түүвэрт хамруулан шалгахад “Бүжнэр” ХХК, “Дорнод хийц” ХХК, “Талын сүлд” ХХК, “Донж өргөө” ХХК, ЦОДММ ХХК-ууд шаардлагатай баримтуудыг ирүүлж, Дөшийн нуруу ХХК, Дорнын оч ХХК-иуд коронавирус өвчинтэй холбоотойгоор хотод байгаа, мөн хувийн шалтгааны улмаас баримт материалаа ирүүлээгүй.

Баримт, материалыг ирүүлсэн гүйцэтгэгчид нь санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Б.3.1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Захиалагч болон зохиогчийн хяналт нь Барилгын тухай хуулийн 37, 38.1.8, “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтууд, холбогдох яамдаас өгсөн чиглэл, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн хэрэгжиж байна.

Төсвөөс захиалагчийн хяналтын зардалд 110,7 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 22.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зохиогчийн хяналтын зардлыг зураг, төсөв зохиогч хувь хүн, аж ахуйн нэгжид олгосон бол захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБ-ын газарт олгосныг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дансанд бүрэн төвлөрүүлж ажилласан байна.

Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ГХБХБГ-аас хяналтын ажлын тайлан, холбогдох материалыг авч гүйцэтгэлийг гүйцэтгэгч болон ашиглагч байгууллагатай хийсэн ярилцлага, санал асуулга, ажлын зураг, бодит нөхцөл байдалтай тулган баталгаажууллаа.

Тус газраас хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын ажлын үр дүнг хангалттай гэж үнэлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд гарч байгаа зөрчил дутагдал нь захиалагчийн хяналтаас шалтгаалаагүй байна.

Харин салбарын бодлогыг хэрэгжүүлэгч аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн холбогдох мэргэжилтнүүдийн төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны ажилд оролцох оролцоо, ажлын чанар хангалтгүй байна.

Б.3.2. Он дамжин гүйцэтгэгдэж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.



Аймгийн ЗДТГ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.5-д заасны дагуу төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой.

Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хувьд санхүүжилтийг олгохдоо журмыг мөрдөж ажилласан эсэхийг үзэхэд Баяндун сумын дотуур байрны ажлын гүйцэтгэл 2019 оны эцэст 30.0 хувьтай байхад 42.3 хувийн санхүүжилт олгосон нь гүйцэтгэлд ногдох дүнгээс 145.5 сая төгрөгөөр илүү байна.

Шалтгааныг ХОХБТХ-ээс тодруулахад *"тухайн онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн зардлыг бүрэн олгоогүй тохиолдолд улсын төсөвт татагдаж, буцаан авахад хүндрэл үүсдэг тул илүү олгосон. Зөрүүг дараа онд нөхөн тооцох боломжтой"* гэсэн тайлбар өгсөн.

Аудитын явцад ажлын гүйцэтгэлд хийсэн хяналтаар Цагаан-Овоо сумын соёлын төвийн ажлын гүйцэтгэл одоогийн байдлаар 80.0 хувьтай байхад санхүүжилт 40.0 хувьтай олгогдсон байгаа нь ажлын үр дүнд нөлөөлж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Б.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2019 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.

ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д *"Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна."* Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5.2.4-т *"төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих"*, 8.5-д *"Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ"* гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаа, 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны явцад хяналт шалгалтыг хамтарсан байдлаар хийсэн байна.

Уг шалгалтаар улсын төсвийн эрх шилжсэн 2018 оны хөрөнгө оруулалтын ажил, мөн олон жил дамжсан, дуусаагүй 4 барилгын ажлын явцыг хамруулсан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2019 оны аймагт эрх нь шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд хяналт шалгалтыг 2020 оны 11 дүгээр сард хийхээр төлөвлөгөөнд оруулж ТЕЗ-аар батлуулсан байна.

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд хүрэх зорилтот түвшинд бүрэн хүрээгүй, үр ашгийн талаарх тооцоо судалгаа хангалтгүй байна.

Б.4.1. Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоогүй, зорилтот үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээ байна.



Улсын төсвөөс Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 18 төсөл, арга хэмжээг төсөвт тусгуулах санал хүргүүлэхдээ, тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр дүнгийн талаар тооцоо судалгаа хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11-д “УТХО-ын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашиг, үр дүнг тооцох аргачлал”-ыг Засгийн газрын гишүүн, хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална” гэж заасны дагуу Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 295 дугаар тогтоолоор уг аргачлал батлагдсан нь баталж 2020 оноос мөрдөж эхлэхээр заасан байна.

Тухайн жилд төлөвлөсөн гүйцэтгэлээс 1003.1 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэгдсэн 2 төсөл арга хэмжээ байна.

Төлөвлөсөн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй, чанаргүй хийгдсэн 3 ТАХ-ний ажлууд байна. Үүнд:

- *Сургуулийн барилгын их засвар /Чойбалсан сум/- Спорт заалны шал муу хийгдсэнээр хүүхдүүд хичээллэхэд сөрөг нөлөө үзүүлдэг. Ашиглагч талаас сэтгэл ханамж дунд, хангалтгүй хийгдсэн гэсэн үнэлгээ өгсөн.*
- *Спорт заалны их засвар /Баяндун сум/-Шалны тэгшилгээ, будаг дутуу хийгдсэн нь будаг ховхорч харагдах байдал талаас муу, ашиглагч талаас сэтгэл ханамж дунд, хангалтгүй хийгдсэн гэсэн үнэлгээ өгсөн.*
- *Сургуулийн барилгын их засвар /Дашбалбар сум/- Спорт заалны шал ховхорсон, дулаан алдалт өмнөх жилүүдээс нэмэгдээгүй, ашиглагч талаас сэтгэл ханамж дунд, хангалтгүй хийгдсэн гэсэн үнэлгээ өгсөн.*

Цаашид “УТХО-ын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашиг, үр дүнг тооцох аргачлал”-ыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Б.4.2. Санхүүжилтийг олгохдоо СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа хэдий ч худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг холбогдох цахим систем /www.tender.gov.mn/-д оруулсан талаарх мэдээллийг гүйцэтгэл, санхүүжилтийн баримтад хавсаргаж, баримтжуулаагүй, 4 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн баталгаа байхгүй байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5.3, 4.5.5 дахь заалтад нийцэхгүй байна.

Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан эсэхийг үзэхэд:

- Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/- Хэрэгжиж дуусаагүй, батлагдсан төсөв 2019 онд 1100.0 сая төгрөг, гүйцэтгэл 221.0 сая төгрөг, 879.0 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 79.9 хувийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж авсан байна.
- Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод, Хэрлэн сум/- Зураг төсөв, ТЭЗҮ-н материалыг хүлээж аваагүй байна. Батлагдсан төсөв 2019 онд 380.0 сая төгрөг, гүйцэтгэл 275.5 сая төгрөг, урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 104.5 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 27.5 хувийг авсан байна.



- Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/-Хэрэгжиж дуусаагүй, 2019 онд 455.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Үүнээс гүйцэтгэлээр 312.3 сая төгрөг, урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 136.7 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 30.0 хувийг авсан байна.

Цаашид гүйцэтгэлийг баталгаажуулахдаа холбогдох журмыг бүрэн мөрдөж ажиллах нь зүйтэй байна.

Б.4.3. Шинээр ашиглалтад орсон барилгуудыг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд ашиглалтад орсон 4 төсөл, арга хэмжээнүүдийг улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын эзэмшилд шилжүүлж, бүртгэл, тайланд тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 оны хичээлийн жилд төрийн өмчийн 2 цэцэрлэг ашиглалтад орж хүчин чадлаараа 270 хүүхэд шинээр хамрагдаж сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 87.2 хувийг хамруулж байгаа нь өмнөх оноос 0.3 хувиар буурсан нь шинээр цэцэрлэгийн барилга баригдсан ч дахин цэцэрлэгийн барилгын хэрэгцээ нэн тэргүүнд шаардлагатайг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга ашиглалтад орж хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн төлөө ажилладаг 5 төрийн бус байгууллага, хөдөлмөр эрхлэлт, халамжийн нэг цэгийн үйлчилгээ, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нэг дор төвлөрч ард иргэдэд үйл ажиллагаа явуулж байна.

Өмнөх онд Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төвийг инженерийн шугам сүлжээнд холбуулж ашиглалтад оруулах тухай зөвлөмж өгсөн нь бүрэн хэрэгжиж, шугам сүлжээний ажлыг дуусган, 2019 онд бүрэн хүчин чадлаараа ажиллаж 24 ахмад настныг асрамжид хамруулсан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2019 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцэж байна.
2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн ч эрэмбэлэх ажил хангалттай үр дүнтэй хийгдэхгүй байна.
3. Барилга, байгууламжийн зураг, төсвийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв нь зургийн дагуу батлагдаагүй байна.
4. ТАХ-ний зураг, төсвийг хийлгэх, магадлалаар баталгаажуулах ажил жил бүр төсвийн хууль батлагдсанаас хойш хийгддэг зөрчил арилаагүй байна.
5. Байршил тодорхойгүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй, төсөл, арга хэмжээг хуульд тусган баталсан байна.



6. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.
7. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний 94.0 хувийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.
8. Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.
9. Зураг хийгдээгүй, ажлын даалгавар дутуу ажлуудад ХАА-г зохион байгуулсан байна.
10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд төлөвлөлтийн хангалтгүй байдал нөлөөлж байна.
11. Хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй байхад ажлыг хүлээн авсан байна.
12. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.
13. Он дамжин гүйцэтгэгдэж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.
14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.
15. Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоогүй, зорилтот үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээ байна.
16. Шинээр ашиглалтад орсон барилгуудыг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

Аудитаар нийт 9,662.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 7,591.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2,070.6 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 2 саналыг хүргүүллээ.



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2020. 04.16 № 7/904
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хэрэгжүүлж ажиллах
тухай

ДОРНОД АЙМАГ ДАХЬ АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Б. Болортуул:

Зурвардас аудитын тайланг
назартай. Аудитаар олон зовлон,
албан шалгуурын зөрчилтөд
наалт мавим ажиллаа.
Аудитын тайланг нэгдсэн
баталгаажуулан, үүнт
хурцүүлж өгснөөр. 14/16
аар.

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр
дүн, үр ашигт хийсэн аудиттай танилцлаа.


Аудитын тайланд тусгагдсан зөрчилтэй асуудлын хүрээнд холбогдох
байгууллагуудад чиглэл өгч, зөрчлийг арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа
бөгөөд тайланд тусгагдсан Баяндун сумын Спорт заалны барилгын их засвар,
Чойбалсан сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварын ажлын
гүйцэтгэгч "Бүжнэр" ХХК, Дашбалбар сумын сургуулийн барилгын их засварын
ажлын гүйцэтгэгч "ЦОДММ" ХХК-д тус тус хугацаатай үүрэг даалгаврыг өгөөд
байна.

Цаашид аудитын тайланд тусгагдсан зөрчил дутагдлыг арилгуулан,
аудитаар ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах болно.

Хавсралт: 10 хуудастай

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



010520750



САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын дутуу хийгдсэн ажлыг шинж чанараас нь хамааран дараа онд шилжүүлж, үлдсэн санхүүжилтийг орон нутгийн төсөвт үлдээх асуудлыг эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэх талаар холбогдох газарт санал хүргүүлэх.
2. Орон нутагт төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлэхдээ журамд заасан хугацааг мөрдөөгүй ТЕЗ-дад тооцох хариуцлагын талаар зохицуулалт бий болгох саналыг холбогдох газарт хүргүүлэх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. Барилга, байгууламжийн зураг, төсвийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын үр дүнг сайжруулах.
2. Төсвийн тухай хуулийн 29.4 дэх хэсэгт заасан холбогдох зөвшөөрлүүд бүрэн олгогдсон төсөл, арга хэмжээг төсөвт тусгуулах.
3. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд гарсан зөрчлүүдийг арилгаж, худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.
4. Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгох.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудад тавих дотоод хяналтыг цаг хугацаанд нь хийж, үр ашгийг тооцон, үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 06

Чойбалсан хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Л.Хишигтогтох, Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

110219094



Тэргүүлэх аудиторын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 46 тоот тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

2020.04.17.

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/
1	Аймгийн ЗДТГ	ГАГ-2020/02-ГА	Зөрчил арилгуулах тухай	906700,0
2	Аймгийн ЗДТГ	ГАГ-2020/02-ГА	Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах тухай	6685000,0
Нийт дүн				7591700,0

